



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 219


Улаанбаатар
хот

"Шивээ-овоо" ХК-ийн техник, технологийг
шинэчлэхэд шаардагдах санхүүжилтийг
шийдвэрлэх тухай

Хөгжлийн банкны тухай хуулийн 7.1.1, 9.3, 11.1, 16.2-т заасныг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төвийн бүсийн дулааны цахилгаан станцуудыг түлшээр найдвартай хангах арга хэмжээний хүрээнд "Шивээ-Овоо" ХК-ийн тоног төхөөрөмжийн шинэчлэлд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Бүгд Найрамдах Польш Улсын Господарства Кражовего (Bank of Gospodarstwa Krajowego) банкнаас 20.9 (хорин сая есөн зуун мянган) сая хүртэлх еврогийн зээл авч холбогдох гэрээ байгуулахыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. "Шивээ-Овоо" ХК-ийн үйл ажиллагааг тогтворжуулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Уул уурхайн сайд Р.Жигжид, Эрчим хүчний сайд Д.Зоригт нарт үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Б.БОЛОР